

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/13/-НА-СТА-ТӨА

БАЯНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага	166
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	18
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
ЗТХЯ	Зам тээвэр Хөгжлийн Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/208
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 16 тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно", 4.1.6-д "Баянчандмань АЗЗА ТӨХК" гэж заасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Удирдлагын зардлын төлөвлөгөөг 402,343.4 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 2023 оны зорилтот түвшний биелэлтээр 434,544.6 мянган төгрөг болж 32,201.2 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ хэтрэлтэд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 458 дугаар шийдвэрээр 15,879.7 мянган төгрөгийн алдангийг Төгс зам ХХК-д, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 2020-2021 онуудад машин механизм,техник тоног төхөөрөмжийн түрээсийн орлогоос 40 хувийг ТӨБЗГ-т төвлөрүүлнэ гэсэн журмыг

зөрчсөн учир 8,792.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр төлсөн зэрэг бусад зардлууд гарсан нь нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	212,282,845.46	357,585,260.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	55,434,785.21	20,842,083.65
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	961,745.35	15,690,493.92
31110	Төгрөг	961,745.35	15,690,493.92
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	54,473,039.86	5,151,589.73
31210	Төгрөг	54,473,039.86	5,151,589.73
31213	Арилжааны банк дахь харилцах	54,473,039.86	5,151,589.73
33	АВЛАГА	17,798,544.93	10,422,857.04
33401	Дансны авлага /ТӨҮГ/	17,798,544.93	10,422,857.04
34	УРЬДЧИЛГАА	0	44,850,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0	44,850,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	139,049,515.32	281,470,319.83
35100	Түүхий эд материал	5,293,329.94	27,900,744.34
35110	Тусгай зориулалттай материал	5,293,329.94	27,900,744.34
35300	Бэлэн бүтээгдэхүүн	70,272,329.85	307,499.08
35400	Хангамжийн материал	63,483,855.53	253,262,076.41
35410	Бичиг хэргийн материал	0	177,939.55
35420	Аж ахуйн материал	0	111,397,642.96
35430	Сэлбэг хэрэгсэл	0	60,163,147.41
35440	Түлш, шатах тослох материал	0	1,391,309.14
35470	Бусад хангамжийн материал	63,483,855.53	80,132,037.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	941,621,216.27	926,164,355.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	941,621,216.27	926,164,355.05
39200	Биет хөрөнгө	729,709,116.27	713,150,796.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	127,155,632.54	127,155,632.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-110,165,917.47	-111,906,980.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	416,181,273.87	458,766,095.51
39204	Хуримтлагдсан элэгдэл	-327,365,415.14	-362,552,867.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,033,765,127.71	1,058,088,827.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-456,236,139.83	-497,584,583.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,080,334.80	88,627,034.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,861,480.21	-47,442,361.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,155,700.00	0
39300	Биет бус хөрөнгө	211,912,100.00	213,013,558.30
39301	Програм хангамж	8,022,500.00	9,822,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-698,541.70
39303	Бусад биет бус хөрөнгө	203,889,600.00	203,889,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,153,904,061.73	1,283,749,615.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	796,007,179.92	1,027,650,307.65
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	588,054,446.92	819,697,574.65
41300	Өглөг	588,054,446.92	819,697,574.65
41360	Бусад өглөг	588,054,446.92	819,697,574.65
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	26,428,788.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	255,061,909.26	282,784,153.33
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	155,982,595.45	238,146,483.29
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	177,009,942.21	272,338,150.03
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	207,952,733.00	207,952,733.00
42200	Урт хугацаат зээл	207,952,733.00	207,952,733.00
42220	Гадаад валют	207,952,733.00	207,952,733.00
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	207,952,733.00	207,952,733.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	357,896,881.81	256,099,307.92
51	Засгийн газрын хувь оролцоо	357,896,881.81	256,099,307.92
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	946,003,905.78	946,003,905.78
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	203,889,600.00	227,295,184.94
51200	Хуримтлагдсан үр дүн	-911,571,163.00	-1,036,774,321.83
51210	Өмнөх үеийн үр дүн	-829,231,817.18	-911,571,163.00
51220	Тайлант үеийн үр дүн	-82,339,345.82	-125,203,158.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	119,574,539.03	119,574,539.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,153,904,061.73	1,283,749,615.57

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	262,042,882.72	309,341,504.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	262,042,882.72	309,341,504.23
120	Нийтлэг татварын бус орлого	262,042,882.72	309,341,504.23
120009	Бусад орлого	5,805,000.00	0
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	1,896,641,289.81	1,520,626,651.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,640,403,407.09	1,211,285,146.77
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	344,382,228.54	434,544,663.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,382,228.54	434,544,663.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,382,228.54	434,544,663.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,382,228.54	434,544,663.06
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	327,562,620.54	330,483,602.34
210813	Бусад зардал /ТӨҮГ/	16,819,608.00	104,061,060.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-82,339,345.82	-125,203,158.83
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-82,339,345.82	-125,203,158.83

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,893,505.78	119,574,539.03	-829,231,817.18	440,236,227.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,149,893,505.78	119,574,539.03	-829,231,817.18	440,236,227.63
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-82,339,345.82	-82,339,345.82
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,893,505.78	119,574,539.03	-911,571,163.00	357,896,881.81
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,149,893,505.78	119,574,539.03	-911,571,163.00	357,896,881.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,149,893,505.78	119,574,539.03	-911,571,163.00	357,896,881.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	23,405,584.94	0	0	23,405,584.94
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-125,203,158.83	-125,203,158.83
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	1,173,299,090.72	119,574,539.03	-1,036,774,321.83	256,099,307.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,090,603,108.99	1,562,381,722.02
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,090,603,108.99	1,562,381,722.02
120	Нийтлэг татварын бус орлого	2,090,603,108.99	1,562,381,722.02
120009	Бусад орлого	31,557,240.00	18,876,288.36
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	2,059,045,868.99	1,543,505,433.66
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,937,082,859.93	1,574,958,423.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,937,082,859.93	1,574,958,423.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,937,082,859.93	1,574,958,423.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,978,884.13	503,109,876.36
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	469,978,884.13	503,109,876.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,000,000.00	63,000,000.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	150,000,000.00	63,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,147,908.47	14,713,340.90
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	11,147,908.47	14,713,340.90
2104	Хангамж, бараа материалын зардал	1,162,263,501.19	788,173,873.40
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	424,367,760.00	468,552,401.40
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	737,895,741.19	319,621,472.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,692,566.14	205,961,332.92
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	61,899,638.78	86,292,414.61
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,579,895.00	124,312.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	80,213,032.36	119,544,606.31
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	153,520,249.06	-12,576,701.56
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	101,817,426.67	42,016,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,817,426.67	42,016,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	101,817,426.67	42,016,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	95,877,426.67	42,016,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	5,940,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-101,817,426.67	-42,016,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	20,000,000.00
14	Бусад эх үүсвэр	109,600,400.00	162,400,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	109,600,400.00	162,400,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	109,600,400.00	142,400,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	109,600,400.00	142,400,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	51,702,822.39	-34,592,701.56
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,731,962.82	55,434,785.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,434,785.21	20,842,083.65

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 он		2023 он		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	өссөн, буурсан	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мян.төг	1,100,000.0	1,902,446.3	1,500,000.0	1,520,626.7	20,626.6	101.4%
	Зам засвар, арчлалтын ажил	мян.төг	900,000.0	1,413,941.5	900,000.0	1,226,055.5	326,055.5	136.2%
	Илэцийн механизм түрээс, болон бусад	мян.төг	200,000.0	488,504.8	600,000.0	294,571.2	(305,428.8)	49.1%
2	Нийт орлого	мян.төг	1,100,000.0	1,902,446.3	1,500,000.0	1,520,626.7	20,626.6	101.4%
3	Нийт зардал	мян.төг	1,061,136.0	1,984,785.6	1,488,569.1	1,645,829.8	157,260.7	110.6%
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	345,306.4	327,562.6	402,343.4	434,544.7	32,201.3	108.0%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг / алдагдал /	мян.төг	38,864.0	(82,339.35)	11,430.9	-125,203.2	(136,634.1)	-1095.3%
5	Цэвэр ашиг / алдагдал /	мян.төг	34,977.6	(82,339.35)	10,287.8	-125,203.2	(135,491.0)	-1217.0%
6	Төсвийн нийт төлбөр	мян.төг	281,401.9	212,866.5	298,127.6	149,292.5	(148,835.2)	50.1%
	А. Орлогын албан татвар	мян.төг	3,886.4	0.0	1,143.1	0.0	(1,143.1)	0.0%
	Б. НӨАТ	мян.төг	100,000.0	23,466.0	150,000.0	43,023.6	(106,976.4)	28.7%
	В. НДШ	мян.төг	117,737.1	150,000.0	85,501.7	63,000.0	(22,501.7)	73.7%
	Г. Хүн амын орлогын татвар	мян.төг	46,562.7	28,759.7	48,267.1	36,067.2	(12,200.0)	74.7%
	Д. Үл хөдлөх хөрөнгийн	мян.төг	4,613.7	6,929.2	4,613.7	1,104.6	(3,509.1)	23.9%
	Е. Гаалийн татвар	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	-	0.0%
	Ё. Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	5,452.0	2,310.4	5,452.0	3,049.8	(2,402.2)	55.9%
	Ж. Бусад татвар	мян.төг	3,150.0	1,401.3	3,150.0	3,047.2	(102.8)	96.7%
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	9,460.0	9,460.0	9,460.0	0.0	(9,460.0)	0.0%
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	44.0	44.0	44.0	44.0	-	
9	Нийт цалингийн сан	мян.төг	452,835.0	502,916.6	551,624.0	561,840.2	10,216.2	101.9%
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	857.6	952.5	1,276.9	1,064.1	(212.8)	83.3%
11	Борлуулалтын орлогоос 1 төгрөгт ногдох зардал	төг	0.96	1.0	0.99	1.1	0.1	109.1%
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	102,433.2	94,033.3	83,361.1	42,924.4	(40,436.7)	51.5%
13	Нийт авлага	мян.төг	60,000.0	17,798.5	10,422.0	10,422.9	0.9	100.0%
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	-	-	-	-	-	0.0%
	Нийт Өглөг	мян.төг	222,352.7	791,880.2	607,444.0	1,027,650.3	420,206.3	169.2%
14	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	25,300.0	583,927.5	399,491.3	819,697.6	420,206.3	205.2%
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	207,952.7	207,952.7	207,952.7	207,952.7	-	0.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ /, түүний үйл ажиллагаа

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн зорилго нь: “Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар арчлалтын гэрээ”-ний дагуу Баянчандмань-Баруунхараа, Улаанбаатар-Лүн чиглэлд нийт 85.6 км замын хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй хангаж, ашгийн төлөө ажиллах”-д оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн дүрэм, 2021/02/007 тоот тусгай зөвшөөрлөөр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Таван км хүртэл хатуу хучилттай зам барих;
- Хайрган хучилттай зам барих;
- Бүх төрлийн зам гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил;
- Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах;
- Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил, үйлчилгээ эрхлэх ;

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 16 тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно”, 4.1.6-д “Баянчандмань АЗЗА ТӨХК” гэж заасан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг ЗТХЯ-ны харьяа байгууллага юм.

Компани 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлдэг.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах даргаар Зам, тээврийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн даргыг томилсон байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороог 2, нэр дэвшүүлэх хороог 3, цалин урамшууллын хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 6 удаа зохион байгуулж, 9 асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн зардлыг 47,746.1 мянган төгрөгөөр баталж, цалинд 47,711.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын хүрээнд “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани байгуулагдсан бөгөөд төрийн өмчийн 20 АЗЗА компанийг нийлүүлэн нэгтгэл болгох тухай тогтоол
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
- ТӨБЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний А-1/194 тоотын дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар тушаал;

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 07 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын нэгжийг шинэчлэн 3 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2023 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 5 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан байна

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 3,018.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан төлж барагдуулсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянчандмань АЗЗА ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/29 тоотгоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,283,749.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 129,845.5 мянган төгрөгөөр буюу 11,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	55,434.8	20,842.1	-34,592.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	17,798.5	10,422.9	-7,375.6
Бараа материал	139,049.5	281,470.3	142,420.8
Урьдчилж төлсөн зардал	0.0	44,850.0	44,850.0
Үндсэн хөрөнгө	941,621.2	926,164.4	-15,456.7
Нийт хөрөнгө	1,153,904.1	1,283,749.6	129,845.5
Өр төлбөр	796,007.2	1,027,650.3	231,643.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	357,896.9	256,099.3	-101,797.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,153,904.1	1,283,749.6	129,845.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага дансны үлдэгдэл буурч, бараа материал, урьдчилж төлсөн зардал, өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 34,529.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эцэст ЗТХЯ-аас гүйцэтгэлээр ажлын төлбөрийн санхүүжилт хийгдэж ажилчдын цалинг бүрэн тавьж олгосон нь нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл 7,375.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 1 байгууллагаас авах ажил үйлчилгээний төлбөрийн авлагыг барагдуулснаас шалтгаалсан байна. Авлагын үлдэгдэл нь 2019 онд үүссэн Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 5,088.4 мянган төгрөг, 2020 онд үүссэн Баяндөл ХХК-ийн 5,334.5 мянган төгрөгийн он дамжсан авлагуудыг барагдуулахаар дахин гэрээ хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 142,420.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд аж ахуйн материалд 111,397.6 мянган төгрөгийн, сэлбэг хэрэгслийн материалд 60,163.2 мянган төгрөгийн нөөц үүссэнтэй холбоотой байна.
- Урьдчилж төлсөн зардалд 2 компаниас зам засвар арчлалтын гол түүхий эд болох асфальт бетон хольц, бетон зуурмаг авахаар 44,850.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,456.8 мянган төгрөгөөр буурсан нь 73,564.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 31,288.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тайлант хугацааны элэгдлийн зардал 79,828.3 мянган төгрөгөөр бодогдсон нь нөлөөлсөн байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 231,643.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн нөөцөлж бэлтгэсэн, өөрийн эзэмшлийн машин механизм, техникүүдэд доголдол гарснаас хувь хүн болон албан байгууллагаас машин механизм, техникийг түрээсээр авч ажиллуулсан үйл ажиллагаатай холбоотой өглөг нэмэгдсэн байна. Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 101,797.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д “ төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”, 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангуулах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 592 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,500,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,488,569.1 мянган төгрөгөөр, 11,430.9 мянган төгрөгийн ашигтай ажиллагаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 83,361.1 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,520,626.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,645,829.8 мянган төгрөгийн зардал гарган 125,203.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,520,626.6 мянган төгрөг болж 20,626.6 мянган төгрөгөөр зам засвар арчлалтын ажлын орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,645,829.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 157,260.7 мянган төгрөг буюу 10,6 хувиар хэтэрсэн гүйцэтгэлтэй байна. Энэ нь үзүүлсэн үндсэн ажил үйлчилгээний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор, машин механизмын түрээсийн зардал их гарсантай холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 42,924.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны алдагдал 125,203.2 мянган төгрөг болж, 11,430.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн ашгийн төлөвлөгөөг биелүүлээгүй нь Машин механизмын түрээс, сэлбэг хэрэгсэл, шатахууны зардал өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40 хувь буюу 17,333.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Баянчандмань АЗЗА ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, урт хугацаат өр төлбөрийн асуудлыг холбогдох газраар шийдүүлж барагдуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянчандмань АЗЗА ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайлангаа Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд, материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр 1,640,403.4 мянган төгрөгийн нийт зардлыг сонгосон.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар буюу 24,606.1 мянган төгрөгөөр тогтоосны 75 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 18,454.5 мянган төгрөгөөр тогтоож, аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянчандмань АЗЗА ТӨХК нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, тус хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахилгаан, халаалт дулааны зардлыг хэмнэсэн боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өсөлт, үнийн нэмэгдлээс шалтгаалан хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 183 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь бүрэн байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

орлогын 1,696,910.2 мянган төгрөгийн 28 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,007,738.9 мянган төгрөгийн 49 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 681,232.6 мянган төгрөгийн 3 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 58,173.3 мянган төгрөгийн 8 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна. Хуулийн хэрэгжилт 100,0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Их Монгол Хөлөг аудит” ХХК гүйцэтгэж, аудитаар 354.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 11,830.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн Fas.audit.mn системд мэдээлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	354.0	1	354.0	100%
Албан шаардлага	3	11,830.7	3	11,830.7	100%
Зөвлөмж	2	0	2	0	100%
Нийцэл-Шилэн данс	1	1,115,422.1	1	1,115,422.1	100%
Нийт дүн	7	1,127,606.8	7	1,127,606.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн Сангийн яам, Кувейтийн сангийн урт хугацаат зээлээр 2007 онд бэлтгэсэн тоног төхөөрөмжийн зээлийн үлдэгдлийг шийдвэрлэсэн байдлыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар дахин тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,054.2 мянган төгрөгийн 2 алдаа¹-г аудитын явцад залруулж, нийт 18,827.3 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 2,415.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 15,879.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 531.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг өмнөх онтой зэрэгцүүлсэн байдлаар тайлагнаагүй, тайланд тодруулга бэлтгэж, иж бүрдлийг хангаагүй алдаа байна. Санхүүгийн байдлын тайлан дахь биет бус хөрөнгө нь тодруулгаасаа 2,054.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан алдаа байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 8 дугаар зүйлийн 8.1.5-д “санхүүгийн тайлангийн тодруулга”, Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” журмын Санхүүгийн тайлан бэлтгэх хэсгийн 5-д “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх” ерөнхий зарчим болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу биелэлтийг тооцож тайлагнаагүй алдаа байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д “орлогын дэлгэрэнгүй тайлан”, 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” журмын Санхүүгийн тайлан бэлтгэх хэсгийн 5-д “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх” ерөнхий зарчим болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын эзэмшлийн автомашины 11 удаагийн торгуулийн 417.6 мянган төгрөгийг, мөн балансаас баланст шилжиж ирсэн 2 автомашины торгуулийн 1,019.1 мянган төгрөг, нийт 1,436.7 мянган төгрөгийг кассаас төлсөн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэсэн заалттай нийцэхгүйгээс

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гадна санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д “.бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Зам засварын ажлын үндсэн биш ажилтай 3 албан хаагчийг замын ажилд дайчлан ажиллуулж, нөхөн амраах боломжтой цаг хугацаанд 979.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон зөрчил байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 458 дугаар шийдвэрээр 15,879.7 мянган төгрөгийн алдангийг Төгс зам ХХК-д төлж, үр ашиггүй зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчим”, 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөнөөс 13 удаагийн гүйлгээгээр 531.7 мянган төгрөгийн цай кофе авч хэрэглэсэн зөрчил байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Мөнгө хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах

2. Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулахтай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Сангийн яам, Кувейтийн сангийн урт хугацаат зээлээр 2007 онд бэлтгэсэн тоног төхөөрөмжийн зээлийн үлдэгдлийг шийдвэрлүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчим”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж: Урт хугацаат өр төлбөрийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн, барагдуулж ажиллах

3. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Нийт мөнгөн гүйлгээний 22,8 хувийг кассаар авч зарцуулсан, кассын ажиллагааны журамд бэлэн мөнгөний орлого хүлээн авах, данснаас зузаатгал хийх дээд хэмжээг тогтоогоогүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Бэлэн мөнгөний зарцуулалтыг багасгах, кассад орлого хүлээн авах, данснаас зузаатгал хийх дээд хэмжээг тогтоох,

Дээрх 3 зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

